



СИ И СИ ИНВЕСТМЕНТ ББСБ ХХК ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

НЭГ. УДИРДЛАГЫН ҮҮРЭГ АМЛАЛТ:

1.1 Си И Си Инвестмент ББСБ ХХК нь дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэхдээ тогтвортой хөгжлийн бодлогод тусгасан зорилт болон зарчмуудыг биелүүлэх, байгаль орчин, нийгэм, засаглалын сайн жишгийг өөрийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээнд шингээж, тогтвортой хөгжлийг дэмжигч хариуцлагатай ухаалаг санхүүжүүлэгч байна.

ХОЁР. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ЗОРИЛГО:

2.1 Си И Си Инвестмент ББСБ нь Ухаалаг хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэгч болохын хувьд тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалт, бүтээгдэхүүн, үйлчилгээндээ ESG (Байгаль орчин, Нийгэм, Засаглал) зарчмуудыг хэрэгжүүлэх юм.

2.2 Энэхүү бодлого нь Монголын ТОС холбоо, Таксономийн 8 зарчим, Монгол Улсын 2050 оны Тогтвортой Хөгжлийн Зорилттой нийцүүлэн боловсруулав.

2.3 Хамрах хүрээ: Энэхүү бодлогыг Си И Си Инвестмент ББСБ ХХК-нийн ТУЗ-ийн тогтоолоор батлуулж, бүх үйл ажиллагаанд ижил түвшинд мөрдөх ба жил бүр хянан, шинэчилнэ.

2.4 2026 оны зорилт:

- ❖ Байгаль орчин нийгэм, засаглалын зарчмуудыг хэрэгжүүлэхийг дэмжих хороо, гүйцэтгэх ажилтныг томилно;
- ❖ Байгаль орчин нийгэм, засаглалын зарчмуудыг хэрэгжүүлэх, Тогтвортой хөгжлийн бодлогыг дэмжих төсвийг тодорхойлж батална.
- ❖ Шинээр судалж олгох зээл болон хөрөнгө оруулалтад Байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн үнэлгээг хийх процесс бий болгох;
- ❖ Ногоон таксономи, тогтвортой хөгжлийн зорилтуудад нийцсэн зээлд хөнгөлөлттэй нөхцөл, урамшууллыг бий болгох;
- ❖ Чанартай боловсрол, Хүйсийн тэгш байдал, Санхүүгийн хүртээмжийн зарчимд нийцсэн Боловсрол бидний ирээдүй хөтөлбөрийн хүртээмжийг нэмэгдүүлнэ;
- ❖ Эрчим хүчний үр ашигтай барилга, EV тээвэр зэрэг Монгол Улсын Ногоон Таксономи-д тусгасан чиглэлд хамаарах Ногоон зээлийн багцыг 1.0 тэрбум төгрөг хүргэх;
- ❖ Тогтвортой хөгжлийн тайланг СЗХ-ны тогтвортой байдлын тайлангийн удирдамжийн дагуу бэлтгэж, жил бүр нээлттэй ил, тод тайлагнах.

ГУРАВ. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧМУУД

3.1 Байгаль орчин, нийгэм, засаглалын зарчмуудыг бүх үйл ажиллагаандаа нэгтгэж, ил тод, хариуцлагатай менежментээр хангана. Үүнд:

3.1.1 Хөрөнгө оруулалтын ESG зарчим

- ❖ Байгаль орчинд ээлтэй хөрөнгө оруулалт: Цэвэр эрчим хүч, ногоон барилга, хог хаягдлын менежмент
- ❖ Нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулалт: Эрүүл мэнд, боловсрол, ЖДҮ дэмжих
- Сайн засаглалтай хөрөнгө оруулалт: Ил тод, ёс зүйтэй компаниудад хөрөнгө оруулах

3.1.2 Зээлийн санхүүжилт өгөх ESG зарчим

- ❖ Ногоон салбарт, эрсдэлийн үнэлгээ
- ❖ ESG үнэлгээ $\geq 70\%$ оноо авсан компаниудад хөнгөлөлт, урамшуулал үзүүлэх

3.1.3 Дотоод үйл ажиллагааны ESG зарчим

- ❖ Оффисын ногоон шилжилтийг эхлүүлэх (Цаас, цахилгаан хэрэглээ, нэг удаагийн хэрэглээг багасгах)
- ❖ Нийт ажилтнуудыг ESG хөтөлбөрт сургалтад жил бүр тодорхой давтамжтай хамруулах
- ❖ Ажилтнуудын тогтвортой хөгжлийг дэмжих санаачилгыг урамшуулах, урамшууллын системд нэгтгэх
- ❖ Ажилтнуудыг эрүүл мэнд, сэтгэлзүйн сайн сайхан байдлыг дэмжих, ажлын байрны аюулгүй байдлыг дээд зэргээр хангах
- ❖ Нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх үүднээс жижиг дунд бизнес эрхлэгчдэд сургалт зөвлөгөө үзүүлэх,

3.1.4 Эрсдэлийн удирдлагын ESG зарчим

- ❖ Эрсдэлийн удирдлагын тогтолцоонд ESG эрсдэлийн үнэлгээний аргачлалыг нэвтрүүлэх
- ❖ Хөрөнгө оруулалт, Зээлийн шийдвэр гаргалтад ESG эрсдэлийн үнэлгээг зайлшгүй хийх түвшинг тодорхойлох

ДӨРӨВ. ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ, ТАЙЛАГНАЛ

4.1 ESG үзүүлэлтүүдийг тогтмол хэмжиж, улирал бүр дотоод тайлан гаргаж, жил бүр хараат бус аудитлагдаж ESG тайланг олон нийтэд ил тод нийтлэх ба хөрөнгө оруулагчид болон оролцогч талуудад тогтмол мэдээлэл хүргэхэд чиглэнэ. Үүнд:

- ❖ ESG зарчмуудын хэрэгжилтийг хагас жилд нэг удаа хэмжих
- ❖ Жил бүр тогтвортой хөгжлийн тайлан гаргах
- ❖ Ногоон зээл, хөрөнгө оруулалтын талаарх мэдээллийг ил тод нийтлэх, тайлагнах

ТАВ. ХАМТЫН АЖИЛЛАГАА

5.1 Монголын ТОС холбоо болон олон улсын санаачилгад идэвхтэй оролцож, орон нутгийн байгууллагуудтай хамтран нийгэмд эерэг нөлөө үзүүлэх төслүүдийг хэрэгжүүлж, салбарын тогтвортой хөгжлийн шилдэг туршлагыг түгээн дэлгэрүүлэхийг зорино. Үүнд:

- ❖ Монголын ТОС холбоонд байнгын идэвхтэй гишүүн байх
- ❖ Орон нутгийн товортой хөгжил, нутгийн захиргаа Төрийн бус байгууллагатай хамтран ажиллах
- ❖ Олон улсын ногоон санхүүгийн санаачилгад оролцох.



CECInvestment

СИ-И-СИ ИНВЕСТМЕНТ ББСБ ХХК

20 25 оны 12 сарын 29 өдөр

№ 25/033

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Тогтвортой хөгжлийн бодлого батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76-р зүйл, “Си и си инвестмент ББСБ” ХХК-ийн /цаашид “Компани” гэх/ Дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн цахим хурлын санал хураалтын хуудсыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн үйл ажиллагааг Тогтвортой хөгжлийн зорилгод нийцүүлэн урт хугацаанд тогтвортой, нийгэм байгаль орчинд ээлтэйгээр явуулах зорилгоор “Тогтвортой хөгжлийн бодлого”-ыг Хавсралт 1 ёсоор баталсугай.
2. Энэхүү тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
3. Энэхүү бодлогыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон байгууллагын зорилго, төлөвлөлт, өдөр тутамд нийцүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал Б.Азжаргалд даалгасугай.

ДАРГА



Х.ГИЙМАА

3F, Monnis Building, Stadium Orgil-22,
Great Mongolian street, 18th khoroo,
Khan-Uul district, Ulaanbaatar 17011, Mongolia

(T) +976 7772 5511
(M) ceci@upg.mn
(W) www.ceci.mn